

МЭДЭЭЛЭЛ

“Байгаль нуурын хөвөө нутаг дахь уулзалт” алдар бүхий сэхээтний асуудлаархи жил тутмын олон улсын эрдэм шинжилгээний

“Сэхээтэн ба үндэсний харилцааны асуудал” сэдэвт ээлжит VII бага хурлын материал дахь зарим чухал философи үндэслэл

/Эрдэм шинжилгээний эргэцүүлэл/

Ц.Гомбосүрэн – МУИС.НШУС.Философийн тэнхмийн багш, профессор

Сршил үг. 1994 оноос эхлэн Буриадын улсын их сургуулийн философийн тэнхим гардан зохион байгуулж тус их сургууль, Байгаль нуурын хөвөө нутаг хоёр дээр болж ирсэн сэхээтний асуудлаархи олон улсын эрдэм шинжилгээний жил тутмын бага хурлын VII нь 2008 оны 9 дүгээр сарын 16-18-нд явагдсан юм. Энэ жилийн эрдэм шинжилгээний хуралд Монгол, Польш, Украин зэрэг орны төлөөлөгчид оролцов. Монголоос дипломатч, доктор Д.Өлзийсайхан, бид хоёр оролцож илтгэл тавьсан болно. Мөн доктор, профессор Д.Дашпүрэв өөрийн бэлтгэсэн илтгэлээ энэ ЭШБХ-д илгээсэн юм. Тухайн жилд сэхээтний асуудлын тодорхой нэг сэдвийг сонгон анхаарлаа төвлөрүүлдэг энэхүү жил тутмын ЭШБХ нь бэлтгэл, зохион байгуулалтын хувьд нийт оросын хэмжээний арга хэмжээ байдаг. Тухайлбал анхны (1994 оны)-хыг нь ОХУ-ын Боловсролын яам, Дээд сургуулийн шинжлэх ухааны олон улсын академи, ОХУ-ын ШУА-ийн Философийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Нийгэм-улс төрийн судалгааны хүрээлэн, Буриадын улсын багшийн дээд сургууль (одоогийн Буриадын улсын их сургууль) хамтран зохион байгуулж байсан бол энэ удаагийн ОУЭШБХ-ыг дээрх байгууллагууд дээр Буриадын Бүгд Найрамдах Улсын боловсрол, шинжлэх ухааны яам, “Социс” сэтгүүл, Олон улсын харилцаа, иргэний санаачлагын хөгжлийн хороо, Оросын социологичдын хөгжлийн хороо, Оросын социологичдын нийгэмлэг зэрэг байгууллага нэмэгдэж хамтран зохион байгуулав.

“Байгаль нуурын хөвөө нутаг дахь уулзалт” гэдэг алдрын доор болдог энэхүү жил тутмын ОУЭШБХ-д бүгдэд нь тэдгээрийг гардан зохион байгуулагчдын нэг, улмаар тэдгээрт илтгэгчээр оролцож ирсэн доктор профессор Иван Иосифович Осинскийгийн 75 насны ойд хүндэтгэл үзүүлсэн арга хэмжээ энэ удаагийн ЭШБХ-ын үед давхар явагдав. Буриадын улсын их сургуулийн философийн тэнхмийн эрхлэгч энэ хүн бол төр, намын удирдах ажил, дээд сургуулийн багшийн ажил хийж ирсэн 50 шахам жилийн хугацаандаа эрдэм шинжилгээний болон сургалтын 440 гаруй бүтээл туурвисны 30 нь бие дааж болон бусадтай хамтарч бичсэн нэг сэдэвт бүтээл, 4 нь сургалтын гарын авлага юм. Онолын ба хавсрага социологи, нийгмийн философи, политологи зэрэг салбарын томоохон эрдэмтэн энэ хүн Дээд сургуулийн шинжлэх ухааны олон улсын академийн академич, ОХУ-ын ба Буриадын Бүгд Найрамдах Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн зэрэг цолтой ажээ.

Сэхээтний асуудлыг авч үздэг энэхүү жил тутмын ОУЭШБХ-ын үйл ажиллагаа Буриадын улсын их сургуулийн философийн тэнхимд төвлөрдөг боловч эдгээр ЭШБХ нь зөвхөн философичдын хүрээнд болдог биш юм. Тухайлбал энэ удаагийн ОУЭШБХ-ын бэлтгэлийг хангахад Буриадын улсын их

сургуулийн бусад олон тэнхим оролцсоноос гадна илтгэгч нар нь социологич, улс төр судлаач, боловсрол судлаач, удирдах ажилтан, түүхч, техникийн ухааны эрдэмтэн, утга зохиол судлаач, сэтгэл судлаач, нийгмийн ажлын мэргэжилтэн, соёл судлаач, шашны зүтгэлтэн, хэлний мэргэжилтэн, сэтгүүлч, философич зэрэг янз бүрийн ажил, мэргэжлийн хүмүүс байлаа.

“Сэхээтний ба үндэсний харилцааны асуудал” сэдэвт энэ удаагийн (VII) ОУЭШБХ-д 120 гаруй илтгэлийн сэдэв ирснийг бүгд хурал ба 5 секцийн хуралд хэлэлцэхээр зохион байгуулах хороо хуваарилсан байв. Тэдгээр илтгэл нь янз бүрийн улсад, ялангуяа Орост эдүгээ гарч буй үндэсний асуудлыг шийдвэрлэхэд сэхээтний роль, байр суурь нь ямар байгааг болон ямар байх ёстойг философи, социологи, угсаатны зүй, политологи, соёл судлал зэрэг салбарын үүднээс хөндөн авч үзжээ.

Одоо уг ЭШБХ-д зориулсан илтгэлүүдэд буй чухал чухал философи үндэслэлийг уншигч нарын сонорт хүргэе.

I. Сэхээтэн гэж хэн бэ? Сэхээтний үйл (функц), гүйцэтгэл (роль), хувь тавилан (миссия)

“Сэхээтэн” гэдэг ойлголтыг философийн үүднээс зөв тодорхойлъя гэвэл хүн амын энэ давхраа улс орны амьдралд ямар статус, рольтой бөгөөд ямар үйл, хувь тавилан бүхий зөв тогтоохоос хамаарах билээ. Иймд энэ асуудлаар тус ЭШБХ-ын материалуудад өгүүлсэн зүйлсийн гол агуулгыг илэрхийлэх зорилт эл өгүүлэлд тавьсан болно.

Зарим илтгэгч сэхээтний тухай марксист-ленинист үндэслэлийг илтгэлдээ сурталчилсан байв. Иймд тэдний хувьд сэхээтэн бол үүргээ биелүүлэхэд чухал өндөр мэргэшлийг тусгай дунд болон дээд боловсролоор олж авсан бөгөөд оюуны хөдөлмөрийг мэргэжлийн хувьд эрхэлдэг тийм хөдөлмөрчдийн томоохон бүлэг мөн.

Үүний зэрэгцээ сэхээтэн бол соёлжсон хүн мөнийг онцлоод соёлын янз бүрийн талын аль нэгийг юм уу зарим хэдийг эзэмшин баримталдгийнх нь үүднээс хүн амын энэ давхрааг олон илтгэгч бие биеэсээ зарим ялгаа бүхий тодорхойлжээ. Тэдгээрээс илүү жинтэй санагдсан заримынх нь агуулгыг илэрхийлье.

-Сэхээтэн хүн бол үнэнд үйлчилдэг, бусдыг хүмүүжүүлдэг, түүний дотор хүний зан суртахууныг шинэчилдэг зэрэг олон үйл бүхий байдаг. Тэдгээрийн дотор шүүмжлэлт сэтгэлгээ бол сэхээтний хамгийн үндсэн үйл байх ёстой;

-Тийнхүү сэхээтэн бол мэргэжсэн ажилтан, мэргэжилтэн, оюуны хөдөлмөр эрхлэгч хүн бүр төдий биш, харин үйлдвэрлэл ба техникийн үйл ажиллагаа, удирдлага, үзэл суртал зэрэгт ажил хэрэгч, бүтээлч ханддаг тийм давхраа мөн;

-Сэхээтэн бол нийгэм дэх зохисгүй хандлага бүхнийг сөрөн зогсож чаддаг;

-Ертөнцийг хөрөнгө, арми, улс төрчид биш, харин оюун ухаан, авъяас удирддаг байх эрин рүү бид дөхөөд байна;

-Сэхээтэн бол мэдлэгийг эзэмшиж, түүнээ аль болох өндөр үнээр зарахын төлөө эрмэлзэгч биш, харин ард түмэндээ үйлчлэгч, ард түмнийхээ боловсрол, соёлын төвшинг дээшлүүлэхийн төлөө тэмцэгч мөн;

-Сэхээтэн бол ёс суртахуунлаг, журамтай, эрсдэлээс үл зугтаагч, нийт хүн төрөлхтөнд үнэнхүү үйлчлэгч мөн.

Сэхээтэн бол ард түмнийхээ эх орныхоо төлөө байх хариуцлагаа бүрэн ухамсарлагч мөн. Уг хариуцлага нь нэн олон талтай байдаг. Үүнд: а) Эрүүгийн хариуцлага. Энэ бол хуулийн үүднээс гэмт хэрэг гэж үздэг үйлдлийг хийсэн хүнд оногддог хариуцлага мөн. б) Улс төрийн хариуцлага. Энэ бол эрх баригч дээд хэсэгт оногддог хариуцлага мөн. в) Эдийн засгийн хариуцлага. Энэ бол улс орныхоо эдийн засгийн амжилттай хөгжлийг болон иргэн бүрийн

материаллаг сайн сайхныг хангах цогц зорилтуудыг шийдвэрлэхтэй холбоо бүхий хариуцлага мөн. г). Түүхэн хариулага. Энэ бол ард түмэн, иргэн бүрт хамаатай ч илүү боловсролтой давхраа болох сэхээтэнд бүр илүү холбогддог хариуцлага мөн. Сэхээтэн бол нийгмийн байр суурийнхаа үүднээс түүхэн тодорхой үе дэх нөхцөл байдлыг, түүний үр дагавар ба цаашдын төлвийг сайн мэдэж, ойлгож байдаг давхраа мөн. д). Иргэний хариуцлага. Энэ бол хүн бүрийн, түүний дотор сэхээтний хамгийн өргөн бөгөөд хамгийн чухал хариуцлага, үүнд хүн төрөлхтөн, эх орон өөрийг нь харъялдаг анги, бүлэг, давхраа, гэр бүл, үр хүүхэд, өөрийнхөө өмнө тус тус хүлээдэг хариуцлага мөн.

-Алсын хараа бол сэхээтний давхраа өөрийгөө ухаарч, хянаж байдаг чадварынх нь нэн чухал нэг илэрхийлэл мөн. Үүнд: үйл ажиллагааныхаа зорилгыг зөв тодорхойлж, үр дүнг нь оновчтой тооцдог байх; янз бүрийн хандлага, баримт сэлтэнд шинжилгээ хийдэг байх; зөрчлийг олж хардаг байх; асуудлыг зөв дэвшүүлдэг байх; үйл ажиллагааны баримтлалыг оновчтой томъёолдог байх; төслийг хэрэгжүүлэх механизмыг боловсруулдаг байх; нөөцийг тогтоодог байх; эрсдэлийг харгалздаг байх; бизнес төлөвлөгөө хийдэг байх; түншүүдийнхээ сонирхлыг хүндэтгэдэг байх; төслийн арилжааны өртгийг үнэлдэг байх; экспертиз хийдэг байх; төсөлдөө засвар оруулж чаддаг байх; шинэ үйл ажиллагааг эхлүүлдэг байх зэрэг юм.

-Орчин үеийн нөхцөлд компьютерийн хувьсгал өрнөж, аж үйлдвэржсэн нийгэмд, улмаар мэдээллийн (аж үйлдвэржсэний дараахь) нийгэмд орж байгаатай уялдаад улс орны амьдрал дахь сэхээтний роль нэмэгдэж байна.

-Сэхээтний маш чухал онцлогуудын нэг нь толерант чанар мөн (энэ тухай хойно авч үзнэ).

Оросын сэхээтний маш чухал шинжүүд болох сэтгэлийн хэмжүүр, үнэнч зан, дэг журам, харамгүй сэтгэл, гэгээрэл ба гэгээрүүлэгч, амьдрах арга, хаана л бол хаана үлгэр жишээ хүмүүжил, үүрэгтээ үнэнч зан, эх оронч үзэл, нийгмийг өөрчлөн шинэчлэх үндсэн хүч болдог, нийгмийн нэр хүнд, оюуны жолоодогч байдаг-энэ бүхэн эдүгээ ч гэсэн үлэмж хэмжээгээр хадгалагдаж байна.

Сэхээтэнд хамааруулж буй энэ тоочилт хэдийгээр хязгаарлагдмал байгаа ч гэсэн нэг дүгнэлт хийж болж байна. Үүнд, сэхээтэн хүний шалгуур бол дээд боловсролтой байх, бас удирдах ажилтан байх, ерөнхийлөн хэлэхэд оюуны хөдөлмөр хийдэг байх хангалтгүй байдаг. Орчин үеийн нөхцөл дэх сэхээтэн бол гишүүд нь мэргэжсэн оюуны хөдөлмөр эрхэлж; соёлын ба ёс суртахууны нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээг хүндэтгэн эзэмшсэн; үүний хамт шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээгээрээ, гэгээрүүлэгч үйл ажиллагаагаараа бусдыг үлгэрлэж байдаг; иргэний ба ажил, мэргэжлийн үүрэг, хариуцлагаа ухамсартай хэрэгжүүлдэг тийм бүлэг хүмүүс мөн.

Сэхээтний тухай ийм ойлголт нь "сэхээтэн", "оюуны хөдөлмөр эрхлэгч нар" гэдэг хоёр ойлголтыг ялгаатай ойлгохыг шаардаж байна. Үүнд, ерийн ухамсрын төвшинд сэхээтэн аваас оюун хөдөлмөр эрхлэгч нар бүгд мөн байдаг ахул философи утгаар тэдний доторхи тэргүүний, идэвхитэй, ажил хэрэгч, бүтээгч, ард түмэндээ шудрагаар үйлчилдэг, хүн амыг үлгэрлэн хөтлөгч зөвхөн тийм хэсэг нь сэхээтэн мөн. Энэ хэсэг бол лам харын ялгаагаараа биш, нийгэмдээ дэвшилттэй роль бүхий байгаагаараа сэхээтний давхраа болж өгдөг. Тодруулан дурдахад марксист-ленинист онолын үүднээс лам нарыг сэхээтний бүрэлдэхүүнд оруулдаггүй байсан бол эдүгээ тэднийг оюуны бүтээлч хөдөлмөр эрхэлдгийг нь зөвшөөрч, улмаар тэд сэхээтний бүрэлдэхүүнд багтдаг байх үндэстэйг заадаг үзэл нийгмийн ба соёлын сэтгэлгээнд давамгайлдаг болжээ.

Тийнхүү сэхээтний тухай философи ойлголт болбоос хууль, эрх зүйн үнэлэмжээс урьд ёс зүйн үнэлэмжид илүү үндэслэн бий болдог.

Сэхээтний тухай ийм философи ойлголтын үүднээс хандвал манай оюуны хөдөлмөр эрхлэгч нар, мэргэжлийн ажилтнуудын нэлээд нь сэхээтэнлэг шинжийг эзэмшээгүй юм уу гэсэн байгаа нь баримттай зүйл мөн. Энд объектив зарим шалтгаан байгаа нь мэргэжлээрээ ажиллах бололцоогүй буй, товчоор хэлбэл өөрийгөө харуулж, идэвх санаачлагаа өрнүүлэх нөхцөл бүрдэхгүй юм уу хангалтгүй байгаа зэрэг юм. Үүний хамт оюуны хөдөлмөр эрхлэгч нар, түүний дотор удирдах ажилтнуудын зарим нь сэхээтэнлэг шинжээ илрүүлэхэд нь тэд ажил, мэргэжлийн чадвараар хангалтгүй; хүнд суртал гаргадаг; ялангуяа авилга, хээл хахуульд автсан зэрэг сөрөг зүйл саад учруулж байна.

Орчин үеийн сэхээтэн гэж хэн бэ? гэдэг талаархи эдүгээгийн шинэлэг ойлголтын үүднээс хандвал тус бага хурал дээр зарим илтгэгч сэхээтний нийгмийн үндсийг тайлбарласан нь хуучинсаг сонсогдож байв. Үүнд, тэдний өгүүлж байгаагаар бол өнөөгийн Оросын сэхээтэн үүсэж буй нийгмийн үндэс нь эдүгээ олон хэцүү асуудалтай тулгарч буй үндэсний залуу үе мөн. Гэтэл ийм тайлбар нь сэхээтний тухай бид дээр дурдсан шинэ ойлголтын үүднээс хандвал хэт ерөнхий бөгөөд дутуу гэгдэхээр юм. Учир нь, нийгмийн үндсийг насаар хязгаарлах зөв үү гэдэг асуулт гарахаар юм. Тэгээд бас залуу хүн бүрийг, оюуны мэргэжсэн хөдөлмөр эрхлэгч нарыг бүгдийг сэхээтэнд хамруулах ёсгүй гэдэг үзэл хүчтэй илрэх болж буйг энд харгалзах ёстой.

II. Үндэстэн ба үндэстэн өөрийгөө ухамсарлахуй

Тус ЭШБХ-д тавьсан илтгэлүүдэд үндэстэн гэж юу болохыг философийн үүднээс ерөнхийдөө хоёр янзаар тодорхойлжээ. Үүнд:

Нэг. Марксист-ленинист философийн аргазүйгээр томъёолсон тодорхойлолт. Энэ арга зүйг баримтлагчдын үзлээр хүн төрөлхтний түүхэн дэх хүмүүсийн анхны тогтвортой нийтлэг нь овог мөн бөгөөд овог нь аймаг, аймаг нь ястанд, ястан нь үндэстэн болж хувирдаг.

Үндэстэн бол нэг юм уу олон ястны нягтралаас урган бүрэлддэг тухай үзэл бол марксист-ленинист философийн ойлголт мөн хэмээн энэ философийг баримтлагч нар сурталчилж ирсэн билээ. Гэвч угтаа тэр үзэл бол сталинист үзэл суртлын ойлголт гэж үзэх үндэстэй байдаг. Үүнд, энэ ойлголт аваас капиталист биш хөгжлийн зам бололцоотойн тухай В.И.Лениний дэвшүүлсэн улс төрийн үндэслэлтэй уялддаг. В.И.Лениний зааснаар бол капитализмаас өмнөх нийгмийн харилцаанд буй хоцрогдсон ард түмнүүд ялсан пролетарийн орон болох Зөвлөлт Оросын тусламжтайгаар капитализмыг алгасаад социализмд орж болно. Энэ ард түмнүүдийг “хүмүүсийн нийтлэгийн түүхэн хэлбэрүүд” гэдэг сталинч философи ойлголтын үүднээс авч үзвэл ястан мөн. Тэгээд хоцрогдмол ард түмнүүд гагцхүү эдийн засгийн нийтлэгийн ачаар, тодруулан дурдвал таваар-мөнгөний харилцаанд үндэслэсэн эдийн засаг бүхий нийгэмд шилжсэн нөхцөлд сая үндэстэн болж хувирч чадна хэмээн марксист-ленинист философи сурталчилж ирсэн түүхтэй. Тийнхүү капитализмаас өмнөх нийгмийн харилцаанд оршдог ард түмнүүдийг үндэстэн болж чадаагүй байдаг гэгч үзэл сурталжсан хэвшмэл сэтгэлгээг онол байдлаар сурталчлах бололцоог ЗХУКН ба Коминтернд энэ философи хангаж өгч ирсэн байна. Ийм сурталчилгааг баримтлах юм боол монголчууд уламжлалт нийгмийнхээ нөхцөлд оршиж байсан үедээ үндэстэн болж чадаагүй; харин ястан байсан байж таардаг. 1966 онд эрх баригч Монгол Ардын Хувьсгалт Нам их хурлаа хийж баталсан IV мөрийн хөтөлбөртөө ардын хувийн аж ахуйтнуудыг нэгдэлд элсүүлж, улс оронд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсны ачаар манай ард түмэн социалист үндэстэн боллоо гэсэн дүгнэлт хийсэн байдаг билээ. Ийм дүгнэлт нь Зөвлөлт Оросын бүрэлдхүүнд багтсан ард түмнүүдийг улс төрийн

хувьд басамжлахад үйлчлэгч үзэл суртлыг эрх баригч МАХН улс орондоо хамаатуулсан аялдан дагасан үнэлэмж байв.

Угтаа Монголчууд XIII зууны эхээр нэгдмэл төртэй болж, нутаг дэвсгэрийн хувьд бас нэгдмэл болсноор үндэстэн болж төлвшсөн бодит түүхтэй билээ. Тийнхүү монголчууд хэдэн арван жилийн биш, харин 800 гаруй жилийн түүхт үндэстэн мөн.

Монгол үндэстэнг эртний түүхтэй гэж буй ийм дүгнэлтийн философи үндэс нь: ястан бол философийн биш, харин угсаатны зүйн онолын ойлголт мөн гэж үзэх байдлаас үүдэлтэй буй.

Хоёр. Үндэстэн бол нэг юм уу хэд хэдэн ард түмэн (угсаатан ба угсаатны бүлэг) нэг улс юм уу нэг улсын доторхи улс төрийн бүрдэл болж нэгдсэн байдал мөн гэсэн тодорхойлолтыг тус ЭШБХ-ын зарим илтгэлд томъёолжээ. Ийм томъёолол нь улс төрийн хүчин зүйлийг онцолж байгаагаараа эдийн засгийн хүчин зүйлийг онцолдог марксист-ленинист философийн тоёмъёоллоос ялгарч байна.

Дашрамд дурдахад үндэстний тухай ийм улс төрийн онолын томъёолол аваас дэлхий дахины өнөөгийн холбогдох онолын ойлгоц, практик хэрэглээтэй тохирч байна.

Монгол үндэстэн бүрэлдсэн нь сталинист үзэл сурталд тайлбарлаж ирсэнчлэн хэдэн аравхан жилийн түүхтэй биш, харин эртний түүхтэйн тухай бидний дээрх тайлбар болбоос үндэстний тухай энэхүү улс төрийн ойлголтонд арга зүйн хувьд тохирч байна. НҮБ бол угсаатны үндэстнүүдийг биш, харин улсын байдалт үндэстнүүдийг өөртөө нэгтгэдгийг энд бас дурдахад тохиромжтой юм. Тийнхүү үндэстний тухай орчин үеийн зонхилогч ойлголтын үүднээс үндэстэн бол өөрийнхөө засгийн газрыг байгуулсан бөгөөд бусад улс ямар нэг хэмжээгээр хүндэтгэдэг нутаг дэвсгэр бүхий ард түмэн мөн.

Үндэстний зарим нь нэг ард түмнээс, харин зарим нь хэд хэдэн ард түмнээс юм уу хэд хэдэн ард түмний хэсгээс (жишээ нь, Их Британи, Швейцари, ОХУ гэх мэт) бүрддэг хэмээн зарим илтгэгч тус ЭШБХ дээр өгүүлсэн юм. Мөн илтгэлүүдийн заримд нь үндэстэн аваас нэг нутаг дэвсгэртэй, эдийн засгийн, улс төрийн болон үзэл суртлын хөтөлбөрөөрөө нэгдмэл, төрийн утга зохиолын хэл нь ерөнхий, тэргүүлэгч соёлтой байх ёстой зэргийг онцолж байлаа. Энэ нь өнөөгийн ОХУ маягийн улсуудад илүү холбогдож байна.

Үндэстэн өөрийгөө ухамсарлахуйн асуудал. Энэ асуудал ЭШБХ-ын нэн чухал нэг сэдэв болж байлаа. Нэгэнт үндэстний асуудал хэлэлцэх сэдэв болж буй нөхцөлд үндэстний сэдлэг (национальная идея), үндэстэн өөрийгөө ухамсарлахуй зэрэг асуудал бол зөвхөн онолын биш, харин ч практикийн хувьд илүү тулгамдсан шинжтэй буй тийм байдалд эдүгээ хүн төрөлхтөн оршиж буй тул энэ ч аргагүй юм.

Тухайн угсаатны ард түмэн аваас үндэстэн (улс) болж хувирах үйл явцаа хурдасгах шаардлага бий болоход юм уу салан тусгаарлах зорилтыг идэвхтэй явуулах болж буй нөхцөлдөө үндэсний сэдлэг хурц илэрхийлдгийг зарим илтгэгч илтгэлдээ тэмдгэлсэн буй.

Оросын ард түмний хувьд үндэсний сэдлэг нэг талаар Оросын түүхэн ахуйн илэрхийлэл, нөгөө талаар хүн төрөлхтөний ирээдүйн ёс суртахууны загвар мөн тухай зарим илтгэгч өгүүлсэн буй. Тэдний тайлбараар Орос бол өрнөдийн түгээмэл шинжтэй түүхийг хэрэгжүүлж чадаагүй тийм азгүйтэн биш, харин Өрнөдөөс өөр иргэншил бөгөөд үнэн алдрын иргэншлийг өрнөдийн либерализмын бүдүүвч рүү чихэж болохгүй. Өөрөөр хэлбэл Орос их гүрэн бол ертөнц төрөл арилжиж буйг, Буян Нүгэл хоёр ялгарахаа больж буйг зогсоох тийм дэлхий дахины түүхэн үүрэгтэй.

Оросын үндэсний сэдлэгийг ийнхүү тайлбарлаж буй байдал нь Оросын сэхээтний аль ч давхрааны дотор Өрнөдийн соёл, төр улсын байгууламжийг Орост үл тохирно хэмээн үзэж, Оросыг өрнөдчилөх, либераль ардчиллыг Орост нэвтрүүлэх оролдлого хэрэгжвэл улс орныг сүйрэлд хүргэнэ гэж үздэг хүн цөөнгүй байгаагийн илэрхийлэл бололтой.

Үндэсний сэдлэгийг хөндсөн илтгэгч нарын өгүүлсэнд монголчууд бид өөрсөддөө харгалзвал зохих чухал санаа цөөнгүй байгаагаас нэгий нь онцолъё. Үүнд, тэдний тайлбарласнаар аливаа ард түмний түүхэн амжилттай ахуйн зайлшгүй нөхцөл нь шүтээн, сэтгэл, бие гурвын нэгдэл бөгөөд түүнийг бас бишрэл, соёл, төрт ёс гурвын нэгдэл гэж болно. Улмаар тэд ийм нэгдэл их Орост ямар онцлогтой талаархи өөрсдийн үзэл, байр суурийг илэрхийлжээ. Тэр байр суурийнх нь үүднээс төрийн үзэл сурталд холбогдох хэсгээс дурдахад Орос бол шударга, аюулгүй, зан суртахуунлаг нийгэм болж чадах хувь тавилантай. Оросын үндэсний занд шударга ёс хуулиас дээгүүр байдаг. Иймээс өрнөдийн нийгмийн баримталдаг Ромын эрх зүйгээс шударга ёсны зарчим Орост илүү өргөн. Оросын түүх бол бусад ард түмнийг хядаж, тэдний соёлыг нь устгасан баримт багатай байдаг. Орос бол “дундын нутаг” байж, бусад аль ч ард түмнээс илүүтэйгээр янз бүрийн иргэншлийг хамааралтай болгож, хүн төрөлхтөн бие биеэ харилцан устгахаас сэргийлж байдаг.

Угтаа ийм үзлийг Оросын сэхээтний славъянчлах чиглэлэийн төлөөлөгчид зөвхөн газар зүйн бодлогын үүднээс төдий биш, харин соёлын онолын өргөн талбарын байр сууринаас сурталчилж ирсэн олон арван жилийн уламжлалтай билээ.

Үндэстэн өөрийгөө ухамсарлахуй аваас оросын ард түмэнд бүрэлдсэн онцлогийн асуудалд зарим илтгэгч анхаарлаа хандуулсан юм. Ийм үйл явцын 4 төвшин Орост бүрэлдсэнийг тэд тэмдэглэжээ. Үүнд: 1). бодгаль хүн өөрийгөө ухамсарлахуй; 2). өвөг дээдэс, ураг төрлөө дээдэлсэн ухамсар; 3). угсаатан өөрийгөө ухамсарлахуй; 4). үндэстэн өөрийгөө ухамсарлахуй—энэ дөрөв болой. Үндэстэн өөрийгөө ухамсарлахуй болбоос тухайн үндэстэн өөрийнхөө зан суртахууны үнэлэмж, улмаар соёл, эдийн засаг, улс төр зэргийнхээ онцлогийн үүднээс өөртөө өгч буй үнэлгээнийх нь үр дүн, улмаар төр улсын ерөнхий үзэл суртлаа, ирээдүйн ерөнхий хөтөлбөрөө төлөвлөхүй мөн гэж тэдгээр илтгэгчид үзэж байна. Тэгээд тэд оросын ард түмэн үндэстэн мөнийхөө хувьд өөрийгөө ухамсарлахуй нь дараахь элементүүдийг өөртөө багтааж буйг тоочсон юм. Үүнд, үндэсний сэдлэг, төрт ёсны мэдрэмж (төрийн өмнө хариуцлага хүлээх, иргэний эрх ба албаа ухамсарлахуй гэх мэт), орос хэл, соёлын нэгдмэл байдлаа зөвшөөрөх, үнэн алдрын шашны бишрэлтэй зэрэг юм.

III. Бусад философи үндэслэлээс

Менталитет (оюуны онцлог). Менталитет бол сэхээтний нэг гол нэг онцлог мөний зэрэгцээ хүн амын аливаа тогтвортой давхраа, угсаатан үндэстэн тус бүрт өвөрмөц байдаг ухамсарт ба ухамсарт биш сэтгэлийн нэгдэл мөн хэмээн зарим илтгэгч тэмдэглэсэн буй. Гэхдээ “менталитет”, монголоор “оюуны онцлог” гэж орчуулж болмоор санагдаж буй нэр томъёоны дор өөр өөр агуулга бүхий санааг судлаачид илэрхийлдэг билээ. Энэ нь менталитет бол тухайн нэг бүхэл бүтэн үндэстэн, үндэсний соёл, ард түмний түүхэн туршлага, тодорхой иргэншил, янз бүрийн соёлын харилцан үйлдлийн механизм, нийгмийн бүтцийн хувирал зэрэг нийгмийн олон талт үзэгдэлтэй янз бүрээр холбогдож, улмаар тийм холбоонуудын аль нэгийг юм уу зарим хэдийг онцлон илэрхийлдгээс хамаардаг гэж болмоор юм. Менталитет бол өөрийн субъектийг бусад, ямар ч ойр боловч субъектээс ялгаж өгдөг тийм оюуны ба сэтгэл зүйн харилцан уялдаат ертөнц мөн. “Минталитет” гэдэг нэр томъёо онолын төвшинд философи, психологи хоёрын харилцан уялдаат категорийг илэрхийлдэг байна.

Өнөөдөр оросын менталитетэд хүй нэгдэл, шударга ёс, эх оронч үзэл, ашиг хонжооноос урд алсыг харсан зорилго бүхий аж төрөх ёс зэргийг дээдэлсэн үзэл санаа давамгайлж байна хэмээн зарим илтгэгч тус ЭШБХ-д зориулсан илтгэлдээ дурджээ. Харин энэхүү менталитетэд сөрөг дүр зураг хүн амын дотор дэлгэрч байгаагаас дурдахад засаглалд итгэдэг итгэл алдарч буй, зан суртахууны үнэлэмжийн шалгуур буурсан зэрэг юм гэж тэд бас тэмдэглэж байна.

Соёл түүний зарим элементэд холбогдох асуудлаас. Зарим судлаачийн дурддагчлан соёлын тухай хэдэн зууд хүрдэг тодорхойлолтыг хэрвээ бид зөв анзаарч чадсан бол хоёр үндсэн бүлэгт хувааж болох юм. Тэр хоёрын нэг нь нийгмийн зүйлийг бүтээж, бас шинэчилдэг арга; нөгөөх нь нийгмийн утгат тодорхой үнэлэмж хэмээн соёлыг тус тус үздэг үзэл мөн. Тэгвэл энэ ЭШБХ-д тавьсан илтгэлүүдэд хоёр тодорхойлолт надад содон санагдсан болно. Тэдгээрийн нэг нь соёлыг мэдлэг олж авдаг үндсэн аргууд болох танин мэдэхүй, үнэлэмж хоёрын аль алины нь цогц мөн гэдэг үзэл мөн. Ийм үзлийн үүднээс соёл бол Үнэн, Сайн, Сайхан гурвын нэгдэл бөгөөд гэхдээ хүн төрлхтний түүхийн өөр өөр үед энэ гурвын аль нэг нь тэргүүлэх ач холбогдолтой байдаг. Үүнд: эртний сэтгэгчид Сайныг, шинэ үеийнхэн Үнэнийг, харин дараа үеийнхэн Сайхныг тэргүүн байранд тавьдаг болсон байна. Ингэхдээ ийм үзэлтнүүд шашны гэгээрлийн үүднээс биш, харин хүн төрөлхтний иргэнлэг соён гэгээрлийн үүднээс асуудлыг тавьж, шийдвэрлэсэн гэмээр байдаг. Тухайлбал: XXI зуунд нийгэм, соёлын дэвшлийг тодорхойлогч хүчин зүйл нь хүн өөрөө байгаа аваас ирээдүйн хөгжлийн нэлээд чухал элементүүд нь боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах болон хүний идэвхтэй үйл ажиллагааны бусад хэлбэр байх болно хэмээн тэд дурдсан буй.

Соёлын тухай өөр нэг үзэл тус ЭШБХ-ын материалуудад тод илэрчээ. Энэ бол соёлыг бүтээх арга, үнэлэмж хоёрын нэгдэл мөн гэж үзсэн үзэл юм. Түүний үүднээс соёл бол тухайн иргэншил дэх хүмүүс амьдарч буй орчинтойгоо харилцан үйлдэлд орох явцад бий болж, түүхийн янз бүрийн субъект уламжлан авч байдаг тодорхой тодорхой чиг баримжаа, сэдэлт, үлгэр загвар, хэлбэр, арга, хэрэгсэл, чин эрмэлзлэл, үзэл зэргийн цогц мөн.

Улмаар илтгэгч нар соёлын тухай философид холбогддог олон чухал үндэслэлийг хөндсөн байна. Тухайлбал:

-Эдүгээгийн ертөнц интеграци (даяаршил), дифференциаци (бүсчлэл) гэсэн эсрэг тэсрэг хоёр хандлагын үйлдлээр дүүрэн юм. Ийм хоёр хандлагын аль нэгний нь түгжигдмэл байх өрөөсгөл байдлыг даван туулах ёстойн сацуу үндэсний соёлыг "дэлхийн" гэгдэгч соёлд бүрэн уусгаж болохгүй. Даяарших явц соёлд улам бүр нөлөөлөхийн хэрээр аливаа үндэсний соёл өвөрмөц байдлаа хадгалах эрмэлзэл улам бүр хүчтэй болж байна.

-Нийгэм ялангуяа тогтвортой биш буй нөхцөлд үндэсний соёл дахь уламжлал чухал ач холбогдолтой байдаг. Уламжлал бол нийгмийн харилцаа ба оюуны үйл ажиллагааны тогтвортой хэлбэр, нийгмийн амьдралын бүх салбарт үйлдлийн хүрээ бүхий байдаг түгээмэл бүрдэл, эрх зүйн албадлагаар биш, харин олон нийтийн санаа бодлын хүчээр оршдог янз бүрийн идэвхитэй зохион байгуулалтын тодорхой хэлбэр мөн.

Уламжлал бол өвлөх механизмын нэг чухал хэлбэр мөн. Үүний зэрэгцээ уламжлал бол шинэчлэлтэй уялддаг. Үүнд, нэгэнтэйгүүр уламжлал нь шинэчлэлийн зайлшгүй урьдач нөхцөл, нөгөөтэйгүүр шинэчлэл бол соёлын шинэ маягийн уламжлалд эх сурвалж болж байдаг. Тиймээс уламжлалт соёлд даяарших үйл явц хүчтэй нөлөөлдөг.

-Өнөөгийн ертөнцөд Оросын эзлэх ёстой байр суурийн талаар гурван үндсэн үзэл Орост байгааг зарим судлаач авч үзжээ. Тэдгээр нь: а). Өрнөдтэй,

ялангуяа Европтой ойртох эрмэлзэл. Энэ бол дотооддоо либераль ардчилсан шинэчлэл хийх үндсэн дээр ардчилсан улсуудын эгнээнд багтаж, улмаар Өрнөдийн үлгэр жишээ улсуудыг Оросын түнш, холбоотон болгох гэдэг чармайлт. б). Оросыг Өрнөдөөс холтгож “дорнод” сонголт хийх эрмэлзэл. Ийм эрмэлзэл нь Өрнөдийн загвараас цэрвэх үзэл юм. в). Оросыг “евразийн” улс болгох эрмэлзэл. Энэ нь Оросын үндэсний сонирхлыг Дорнод руу хүчтэй хамруулж, Оросыг Дорнод, Өрнө хоёрыг холбогч гүүр болгох гэсэн үзэл юм.

-Оюуны соёлын төрлүүдийг сонгодог биш философийн үүднээс тайлбарлахаас хүртэл цааш явж, сонгодог бишийн дараахь философи байр сууринаас авч үзэх байдал зарим зарим судлаачийн хэлсэн үгэнд илэрчээ. Ялангуяа хэл, шинэчлэх ухаан хоёрт холбогдсон тайлбарт үүнийг хамаарулж байна. Зарим илтгэгчийн өгүүлснээр хэл бол хүний сэтгэлийг тодорхойлдог өвөрмөц тэмдгийн тогтолцоо, тухайлбал угсаатан өөрийгөө ухамсарлахуй хөгжих нэн чухал нөхцөл, тийнхүү нийгэм, соёлын бодит байдлын илэрхийлэл төдийгүй бас үндэс нь мөн. Хэлний тухай ийм үзлийг илэрхийлэн “хэлэн ухамсар” гэдэг ойлголт эдүгээ бий болсон аж.

Сонгодог бишийн дараахь философи дүгнэлт аваас хэлэнд холбогдохдоо нийгэм, соёлын энэ үзэгдлийн үйл, зорилтуудыг нэлээд эерэгээр үнэлсний илэрхийлэл болж буй гэгдэж болохоор юм. Учир нь, уг дүгнэлтийн үүднээс хэл бол хүний сэтгэлийг тодорхойлдог өвөрмөц тэмдгийн тогтолцоо мөн бөгөөд тухайлбал бие хүн үндэс угсаагаа ухамсарлах гадаад гол нөхцөл мөн. Гэтэл энэ философи шинжлэх ухааныг ихээхэн сөргөөр үнэлдэг. Тийм сөрөг үзлийг илэрхийлэгчдийн үүднээс шинжлэх ухаан агуулгын хувьд Үнэн биш, бас Цэцэн (үнэлэмж) биш бөгөөд бас нийгмийн үр дагавараараа зан суртахуунлаг биш, хүмүүнлэг биш, эвдэн сүйтгэгч зэрэг сөрөг шинжүүд бүхий юм. Өөрөөр хэлбэл шинжлэх ухаан дэвшүүлсэн асуудлаа үнэн шийдвэрлэх бололцоо, чадавх нь хязгаарлагдмал байж, тодорхой асуудлыг үнэн шийдвэрлэлээ ч түүний нийгмийн зориулалт нь шударга биш, хүмүүнлэг биш, байгальд ханддаг хандлага нь эвдэн сүйтгэгч зэрэг үйлдэлд ихээхэн үйлчлэх шинж бүхий байдгийг илтгэгч нар иш үндэс болгох үндэс дээр тэд тийм дүгнэлт хийж байна. XIX зууны 60-аад онуудаас хойш Өрнөдийн улсуудын төр нь Шинжлэх ухааны Академиудаа санхүүжүүлэхээ зогсоож, харин тэдгээр байгууллага өөрийгөө санхүүжүүлэх арга чарганд шилжсэнийг зарим судлаач дурдахдаа шинжлэх ухаан аваас агуулга, нийгмийн үнэлэмж аль алины үүднээс нэр хүнд нь нэлээд унасантай тийм баримтыг тэд холбожээ.

Үүний зэрэгцээ нийгмийн үйл ажиллаганы тодорхой хүрээ ба тодорхой нөхцөлд шинжлэх ухаан эерэг зориулалт, үйл, гүйцэтгэл бүхий байдгийг олон илтгэгч өгүүлсэн буй. Тухайлбал ийм үзлийн үүднээс байгалийн ухаанууд төдийгүй нийгмийн шинжлэх ухаан болбоос онол, практикийн олон чухал ач холбогдолтой буйг тэд баримт түшин өгүүлсэн юм. Гэхдээ шинжлэх ухааныг зохион байгуулах сонгодог (өөрөөр хэлбэл үнэнийг илэрхийлдэг эцсийн зорилго бүхий) загвар үеэ өнгөрөөснийг тэд тэмдэглэж байна. Үүнд, шинжлэх ухааныг зохион байгуулдаг сонгодог бишийн дараахь буюу эдүгээгийн загвар болбоос үнэнийг нээх зорилтыг нийгэм аюулгүй байх; мөн соёл, зан суртахуун, байгаль хадгалагдах зэрэг шаардлагуудтай гарцаагүй уялдуулдаг байхаас өөр замгүй болсныг тэд илтгэлдээ дурсан буй.

Нийгмийн шинжлэх ухаанд холбогдох чухал чухал философи эрэгцүүлэл тус ЭШБХ-ын нэлээд илтгэлд тусгагдсан юм. Тухайлбал байгалийн шинжлэл, нийгмийн ухаан хоёрын харилцааны асуудлыг зарим илтгэгч хөнджээ. Тэдний тайлбараар байгалийн шинжлэл нь танин мэдэх ба практикийн гэдэг хоёр үйл (функци) бүхий байдаг ахул нийгмийн шинжлэх ухаан нь эдгээрээс гадна чөлөөлөх (өөрөөр хэлбэл хуурамч ухамсар, үзэл суртлын гуйвуулга зэргээс

ангигруулах) үйл бүхий байдаг. Тиймээс нийгмийн ухааны эрдэмтэн хүнд гурван чухал гүйцэтгэл байх ёстой. Тэдгээр нь: а). үзэл суртал, улс төрийн хувьд төвийг сахиж, шинжлэх ухааны хамтлагийн жинхэнэ гишүүн байх ёстой. б). Шинжээч, зөвлөгч байж, эрх мэдэлтнүүдтэй зан суртахуун, хууль-эрх зүйн шударга хэм хэмжээний үндсэн дээр харьцдаг байх. в). Халамжлагч, соён гэгээрүүлэгч байж, иргэний нийгмүүдтэй нягт холбогдож, энэ харьцаандаа эрх баригчдын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг байх зэрэг мөн.

-*Шашин*. Шашин бол угсаатны соёлын илэрхийлэл, үндэсний соёлыг хадгалагч мөнгийг тус ЭШБХ-д оролцогчдын зарим нь илтгэлдээ хөнджээ.

-*Реклам*. Орчин үеийн соёлын нэг чухал элемент, түүний хөгжлийн төвшингийн нэг чухал илэрхийлэл нь реклам болж хувирсан билээ.

Энэ тухай асуудлыг зарим илтгэгч авч үзэхдээ реклам бол залуучуудыг нийгэмшүүлэх нэг чухал хүчин зүйл, өөрөөр хэлбэл хүнийг нийгмийн шинэ шинэ гүйцэтгэл (роль) ба үнэлэмжтэй болгох, янз бүрийн нөхцөлд авир үйлдлээ тохируулах, тодорхой хэвшмэл дүрмүүд бүтээх зэргийн арганд дасгах нэг чухал зохион байгуулалт болохыг онцолжээ.

Үнэлэмж. Үнэлэмж бол олон чухал үйл бүхийг судлаачид илрүүлэн заадаг билээ. Энэ ЭШБХ дээр үнэлэмж бол аливаа соёлын үндэс, суурь болж өгдгийг онцолсон үгс илүүтэй сонсогдсон юм. Ялангуяа нийт хүн төрөлхтний үнэлэмжүүдийг бодгаль ухамсар эзэмших асуудалд зарим илтгэгч анхаарлаа илүү хандуулж байлаа. Нийт хүн төрөлхтний үнэлэмжүүд аваас хүмүүсийн авир үйлдлийг тохируулагч мөнгийг хувьд нийт хүн төрөлхтний ухамсрыг үүтгэгч, нэн түрүүнд сайн үйл, талархал, бусдыг ойлгох, хайр, найрамдал, эх оронч үзэл зэргийг сэдэгч мөнгийг тэд илтгэлдээ дурдсан юм.

Айдас, эрсдэл хоёр. Соёлын хэм хэмжээ, соёлын аливаа үнэлэмж аваас янз бүрийн аюул, эрсдэлийг үнэлэхэд тодорхойлогч ач холбогдолтой хэмээн энэ ЭШБХ-д илтгэгч нар тэмдэглэсэн буй. Ер нь олон нийтийн дотор түргэн тархсан зарим айдас болбоос олон түмний соёлын жич жич элемент болж өгдгийг тэд дурдсан байна. Яагаад гэвэл олон нийтийн айдас нийгмийн болон соёлын хамааралд үүсч, ихээхэн хэвшмэл шинжтэй болж байдаг гэж тэд илтгэлдээ үндэслэн дурдсан юм. Тийнхүү олон нийтийн айдас бол нийгмийн хэлбэрийг болж, ингэхдээ бодгаль жич жич айдсыг агуулж байдаг. Тэр нь дайн, улс төрийн ба эдийн засгийн хямрал, хувьсгал гэх мэт хурц асуудал гарсан үед болон байгалийн гамшиг болж буй үед төрж байдаг. "Айдас" гэдэг ойлголт олон утгатайг зарим илтгэлд дурьдаад улмаар Н.Бердяевийн холбогдох ойлголтыг онцолсон юм. Оросын энэ философичийн бичсэнээр айдас бол хүнийг боолчилж байдаг бөгөөд айдас, боолчлол хоёр бол хүний бодит биш экзистенцийг бүтээгч гав мөн. Хэрвээ хүн өөрийгөө боолчлогч болсноо мэдэвчээс ноён болох гэдэг. Ноёрхол аваас алахад хүргэдэг. Төр ямагт айж байдаг тул алахад хүрдэг бөгөөд харин үхэлтэй тэмцдэггүй эрх мэдэлтнүүд бол жигшүүртнүүд мөн.

Энэ мэтээр "эрсдэл", "заналхийлэл" зэрэг ойлголтын философи утганд илтгэгч нар анхаарлаа хандуулсан юм. Тэгээд эрсдэлийг материаллаг (эд, хөрөнгөө алдах); биеийн (эрүүл мэнд муудаж, алдагдах); сэтгэлийн (бухимдал, барьц алдах); нийгмийн (ажил, албан тушаал, байр суурь зэргээ алдах); эдийн засгийн (санхүүгийн алдагдал, хадагламж нь үнэ цэнэгүй болох) гэх мэтээр ангилсан буй.

Толерант (тэвчих) *зарчим*. Англиар "toleration" гэж байдаг үгийг орос хэлэнд "терпимость" (тэвчээр) хэмээн орчуулж, нийгмийн сэтгэлгээний болон улс төрийн ном зохиолуудад чухамхүү тийм (тэвчих) ёс суртахууны шинжийг илэрхийлсэн ойлголтын нэр болгон ашигласан нь элбэг байдаг билээ. Харин энэхүү ЭШБХ-д тавьсан зарим илтгэлд "toleration" гэдэг нийгмийн сэтгэлгээний

ойлголтыг “тэвчээр” гэдэг ойлголтоос их багтаамжтай ашиглаж, түүндээ “нийгмийн” гэдэг тодотгол нэмсэн буй. Тэгээд: нийгмийн толерант зарчим бол (бие хүн, нийгмийн нийтлэг, нийгэм бүхэлдээ гэх мэт) нийгмийн тухайн субъект аваас нийгмийн бусад субъекттэй, соёлын өөр хэв маягийн хүмүүстэй харилцан үр бүтээлтэй хамтарч ажиллахад бэлэн байдаг чадвар мөн гэсэн үзэл, баримтлалыг илэрхийлсэн юм. Тийм үзлийн үүднээс толерант зарчим бол хүн нийгэмшсэний үр дүн, тухайн соёлыг хэрхэн эзэмшсэнийх нь чухал үзүүлэлт мөн.

Гэхдээ “толерант зарчим” гэдэг ойлголт “тэвчих зарчим” хэмээн орчуулахад болохгүй газаргүй бөгөөд гагцхүү энд “тэвчих” гэдэг үгэнд онолын жич утга орсныг мартаж болохгүй.

Угтаа толерант зарчим аваас хүн амын олон бүлэгт байдаг чадвар мөн. Гэхдээ чухамхүү сэхээтний гарцаагүй нэг чадвар нь толерант зарчим байх ёстой. Учир нь, нийгмийн соёлын энэхүү элемент бол боловсролын төвшин өндөр зөвхөн тийм субъектэд байж чадах нийгмийн ба ёс суртахууны шинж ба чадвар мөн гэж энэ асуудлыг хөндсөн илтгэгч нар үзсэн байна. Өөрийнхөө соёлыг төдийгүй бусад ард түмний соёлыг судлах нь толерант зарчмаар хүмүүжүүлэх нэг чухал арга мөн гэж тэд өгүүлсэн буй.

Нийгмийн толерант зарчим бол хүмүүсийн авир үйлдэл, ухамсар аль алины хэм хэмжээ мөний хувьд экстремизм (бусдыг хэвцгийгээр үл таашаах), конформизм (бусдыг зүгээр л идэвхигүй хүлээж авах) хоёрын аль алинтай эвлэрдэггүй хэмээн энэ ЭШБХ-д оролцогчид бас тэмдэглэсэн юм.

Зарим илтгэгч нийгмийн толерант зарчим илэрдэг төрлүүдийг дараахь байлдаар ангилсан нь шинжлэх ухааны төдийгүй зарим талаар философи ач холбогдолтой буй. Үүнд:

*Нийгмийн ба биологийн харилцан уялдаат, өөрөөр хэлбэл хүнийг амьтан мөний нь хувьд үйлдвэрлэх, хамгаалахтай холбоо бүхий хүрээн дэх толерант зарчим. Энэ зарчим болбоос угсаатны, арьсны өнгөний, насны, хүйсийн, эрүүл мэндийн ялгааны гэх мэт салбар дахь толерант зарчмыг агуулдаг.

*Хүн ам зүйн нийгмийн хүрээ буюу хүмүүс хамтран амьдарахаас өөр замгүйгээс хамаармал хүрээний толерант зарчим. Энэ бол хаана амьдарч буй, амьдрах нөхцөл, хэний удам угсаа гэх мэтийн хүрээн дэх толерант зарчмыг агуулдаг.

*Эдийн засгийн хүрээний толерант зарчим. Энэ зарчим аваас материаллаг баялгийг үйлдвэрлэх, хэрэглэх, хуваарилах харилцаанд тал бүрийг нягт харгалзсан толерант зарчим байх ёстойг илэрхийлдэг.

*Улс төрийн хүрээний толерант зарчим. Энэ бол төрийн засаглалыг олж авах, тогтоон барих салбарт хүн ам аваас улс төрийн ба эрх зүйн толерант зарчим бүхий байх ёстойг илэрхийлдэг зарчим мөн.

*Соёлын хүрээний толерант зарчим. Энэ бол хүмүүсийн янз бүрийн нийтлэг аваас боловсрол, шашин, мэдээллийн үйл ажиллагаа, хэл яриа зэргийн хүрээндээ илэрхийлдэг байх ёстой зарчим мөн.

Нийгмийн толерант зарчмыг ийнхүү ангилах байдалд шүүмжлэлтэй хандаж болох авч манай энэ өгүүлэлд тийм зорилт тавих албагүй гэж үзэж байна.

Тус ЭШБХ-ын хүрээнд соёлын философийн ямар ямар асуудал хөндсөнийг товч илэрхийлэхэд ийм байна.

Адилтгал ба нийгмийн философийн зарим асуудал. Латинаар “identificare”, оросоор түүнийг “идентичность” хэмээн галигладаг нар томъёог бид “адилтгал” хэмээн орчууллаа.

“Адилтгал” гэдэг ойлголт логик, хүмүүнлэгийн ухааны олон салбар, философи (ялангуяа сонгодог биш философи) зэрэгт ашиглагддаг. Тэхдээ философичид гэхэд л тэд уг ойлголтыг өөр өөр агуулгаар тайлбарласан дайралддаг. Тэр бүгдийн хамгийн ерөнхий санааг илэрхийлэн тодорхойлоход адилтгал бол

тухайн юм өөрийнхөө тасралтгүй өөрчлөлттэй уялдаатайгаар өөртэйгөө ба бусадтай харьцаад өөрийгөө илрүүлэхүй мөн. Тийм илрүүлэхүй (буюу адилтгал) хоёр үндсэн аргаар хэрэгждэг. Үүнд: а). тухайн юм өөрийгөө бусдаас ялгаатайг тогтоохуй; б) тухайн юм бусдыг тодорхой харилцаанд дуурайхуй.

Тус ЭШБХ адилтгалын дараахь төрлүүдийг онцолсон юм. Үүнд: а). Ард түмнүүдийн адилтгал. Жишээ нь, Баруун Европын улсууд иргэншлийн хувьд АНУ-тай нэг хэв маягийн боловч нутаг дэвсгэр, соёлын олон хүчин зүйлээрээ АНУ-аас ялгагдаж, харин өөр хоорондоо бол олон ард түмний нэгдмэл нэг бүл болж байдаг. б). Угсаатны адилтгал. Зарим илтгэлд буй жишээг үндэс болгоход украин, орос хоёр түүхэн гарал, соёл, нийгмийн шинж зэрэг олон зүйлээрээ ойр боловч украинчууд бол оросууд биш юм. в). Биехүний адилтгал. Бодгаль хүн бусад хүнтэй заавал харьцаж байж, бусдыг өөрийнхөө загвар, үлгэр жишээ болгодгийнхоо ачаар өөрийгөө адилтгаж, өөрийгөө онцолж, илэрхийлж байдаг.

Нийгмийн баримжааны философи асуудал. Аль ч илтгэлийн агуулга дахь маш чухал нэг онцлог бол тэдгээрт үндэсний үзэл, эх оронч үзэл шингэмэл буй. Харин илтгэгч нарын нийгмийн баримжаа ялгаатай буй. Ер нь өнөөгийн ертөнцөд Орос улс ямар замаар хөгжвөл зохих ёстойн талаар гурван үндсэн баримтлал байгааг зарим илтгэгч дурджээ. Тэдгээр баримтлал энэхүү ЭШБХ-д оролцогчдод бас хамаарахаар юм. Тэдгээр нь: 1. *Өрнөдийг баримжаалдаг баримтлал.* Онолын хувьд уг баримтлал либерализмыг сонгосон байна. Практик дээр энэ баримтлалынхан Өрнөдийн орнуудыг Оросын холбоотон, түнш болгохыг, эх орноо ардчилсан улсуудын эгнээнд оруулахыг чухалчилж байна. 2. *Либераль сонголтыг илт эсэргүүцэгчид.* Жишээ нь зарим илтгэгчийн өгүүлснээр либераль хэрэглээний нийгэмд хувийн амжилт, хувийн амьдралын эрх чөлөөг нийгмийн баримжаа болгоод аливаа уламжлал, чин эрмэлзэл, ерөнхий зорилгыг үгүйсгэдэг. Энэ нийгэмд ёс суртахуунлаг биш хүмүүсийн догшин даажигнаан ноёрхож, харин өрөвч сэтгэл, нигүүлсэл, ах дүүсэг ёс, бусдын төлөө үзэл гэх мэт нийт хүн төрөлхтний ёс суртахууны зарчмууд үйлчилдэггүй гэж тэд бас шүүмжилж байна. Гэвч тийм үзэл нь "их Орос" гэдэг бахархлыг бардамналаар сольсонтой, дэлхийд Орос онцгой гүйцэтгэлийн хувь заяатай гэсэн нийгэм, улс төрийн баримтлалтай, дэлхийн олон арван улс дахь либераль шинэчлэлийн чухал чухал ололтыг цулгүй үгүйсгэсэн байр суурьтай тус тус шууд холбогдож байна. 3. Өөр нэг нийгэм, улс төрийн баримтлал бол "евразийн" баримтлал мөн. Энэхүү баримтлалын үүднээс Орос бол газар зүйн байрлал, соёлын уламжлал хоёрынхоо онцлогийн үүднээс Дорно, Өрнө хоёрыг холбогч гүүр болж өгөх ёстой. Энэхүү баримтлал аваас ЗХУ-ын бүрэлдхүүнд байсан улсуудад амьдарч буй оросуудын эрх ашигт болон Оросын үндэсний сонирхлыг Дорнод руу улам гүн нэвтрүүлэх зорилтонд нийцэж байна.

Орос улсад нийгэм, эдийн засгийн эерэг өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхэд сэхээтний роль чухал буйг олон илтгэгч тэмдэглэжээ.

Х

Х

Х

Улаан-Үд хотноо сэхээтний асуудлаар жил тутам болдог олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ээлжит (VII) бага хурлын материал дахь философи үндэслэл, томъёолол, тайлбаруудыг онцлон энэ өгүүлэлд авч үзэж байгаа нь хүмүүнлэгийн ухааны бусад чиглэл, олон салбарын үүднээс, улмаар практик үр ашгийн үүднээс энэ ЭШБХ бас нэн чухал ач холбогдолтой болсныг бүрхэгдүүлэхэд хүргэх ёсгүйг зориуд тэмдэглэе.

Резюме

В статье "Важные философские положения в материалах VII Международной научной конференции "Байкальская встреча" по теме "Интеллигенция и

проблемы национальных отношений" её автор излагает читателям общее научно-практическое значение ежегодных международных конференций "Байкальская встреча" по проблемам интеллигенции, главным организатором которых является кафедра философии Бурятского государственного университета.

Статья состоит из трёх разделов. В I-ом разделе, названном "Кто же такое интеллигенция? Функции, роль и миссия интеллигенции" затрагиваются главные функции и ответственности интеллигенции, подчеркнутые докладчиками, такие, как служитель истине, просветитель, воспитатель, обновитель нравственности, критический мыслитель, патриот и черты которых дальновидность, толерантность и верность, честность и порядочность, примерность и творческая инициатива и т.д. и отсюда автор статьи делает вывод, что понятия "интеллигенция" и "лица, занимающиеся умственным трудом" не одни и те же и он формулирует собственное определение понятия "интеллигенции", которое более основывается на моральной ценности, нежели юридически-правовых нормах.

II раздел статьи гласит: "Нация и национальное самосознание". Здесь автор статьи пишет, что различные понятия нации, которые существуют в докладах, озвученных на данной научно-теоретической конференции, в основном, можно подразделять на две группы. Одна из них - определение марксистско-ленинского философского типа; а другое - это главенствующее определение в современном духе.

При этом автор статьи добавляет, что марксистско-ленинское (на самом деле сугубо сталинское) понятие о народности как исторической самостоятельной форме общности людей, относящейся к народам, находящимся в докапиталистических классовых обществах имеет не теоретический и научный, а лишь идеологический характер и оно служит такому ложному выводу, что народы, находящиеся в докапиталистических формациях не могут превращаться в нацию. Однако, пишет автор статьи, на монгольской земле нация формировалась уже в начале XIII века благодаря созданию единого государства и обеспечению территориального единства со стороны монголов на своей земле. Он также пишет, что данный вывод соответствует современному широко распространенному положению о нации как исторической форме людей, которая состоит из одного или нескольких народов (этносов, этнических групп), объединенных рамками государства или государственности и это положение одобрительно отмечалось в некоторых докладах конференции.

III раздел статьи посвящается следующим актуальным философским вопросам, затронутым многими докладчиками на этой международной конференции, а именно: специфики менталитета различных слоев общества и особенно интеллигенции; культура и её элементы и нормы с точки зрения классической, неклассической и постнеклассической философии; социальная идентичность, общественные ориентации различных представителей интеллигенции и другое.

.....